



ГОЛОМТ БАНКНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ШИЙДВЭР

2026 оны 04 сарын 06 өдөр

№ 00/01

Улаанбаатар хот

Голомт банкны 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах тухай

Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.7, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, Голомт банкны дүрмийн 8 дугаар зүйлийн 8.2.8 дахь заалт, Хувьцаа эзэмшигчдийн 2026 оны 04 сарын 06-ны ээлжит хурлын санал хураалт, Тооллогын комиссын шийдвэрийг тус тус үндэслэн ШИЙДВЭРЛЭХ нь:

1. “Голомт банк” ХК-ийн 2025 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн үр дүн, хөндлөнгийн аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ГАНБОЛД



ГОЛОМТ БАНКНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ШИЙДВЭР

2026 оны 04 сарын 06 өдөр

№ 00/02

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны төсөв батлах тухай

Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.9 дэх заалт, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт, Голомт банкны дүрмийн 8.2.12 дахь заалт, Хувьцаа эзэмшигчдийн 2026 оны 04 сарын 06-ны өдрийн ээлжит хурлын санал хураалт, Тооллогын комиссын шийдвэрийг тус тус үндэслэн ШИЙДВЭРЛЭХ нь:

1. “Голомт банк” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны цалингийн төсвийг хавсралтаар баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ГАНБОЛД

Голомт банкны 2026.04.06-ны
ХЭХ-ын 00/02 тоот шийдвэрийн
Хавсралт №1



Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны төсөв

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн	Цалин 2026 төсөв	Жилд нийт 1,656,801,079
---	---------------------	----------------------------



ГОЛОМТ БАНКНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ШИЙДВЭР

2026 оны 04 сарын 06 өдөр

№ 00/03

Улаанбаатар хот

Голомт банкны дүрмийг батлах тухай

Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.1 дэх заалт, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, Голомт банкны дүрмийн 8.2.1 дэх заалт, Хувьцаа эзэмшигчдийн 2026 оны 04 сарын 06-ны ээлжит хурлын санал хураалт, Тооллогын комиссын шийдвэрийг тус тус үндэслэн ШИЙДВЭРЛЭХ нь:

1. Голомт банкны шинэчлэн найруулсан дүрмийг энэхүү Тогтоолын Хавсралт №1-ийн дагуу баталсугай.
2. Энэхүү Тогтоолын Хавсралт №1-ээр шинэчлэн баталсан Голомт банкны дүрмийг Улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэх, холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал /А.Одонбаатар/-д даалгасугай.
3. Энэхүү шийдвэр батлагдсантай холбогдуулан Голомт банкны Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 04 дүгээр сарын 26-ний өдрийн 00/06 тоот шийдвэрийн Хавсралт №2-аар батлагдсан “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ыг хүчингүй болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ГАНБОЛД